



МОРИН ХУУР ХӨГЖИМД ХАНДАХ ХАНДЛАГЫН ХЭМЖҮҮРИЙН НЭГЭН ХУВИЛБАР БОЛОВСРУУЛЖ ТУРШСАН НЬ (МУБИС, БС-ийн оюутнуудын жишээн дээр)

С.Батхуяг^а, Б.Өсөхбаяр^б, Sarenchoogetu^в

^аМУБИС-Багшийн сургууль, багш, доктор;

^бМУБИС-Багшийн сургууль;

^вҮндэсний их сургууль; БНХАУ ӨМӨЗО, Тонляо

Холбоо барих зохиогч: batkhuyag@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2024.08.25

Хянагдсан: 2024.09.20

Зөвшөөрсөн: 2024.10.25

Хураангуй

Энэхүү судалгаа нь монголын хөгжмийн боловсролын соёлын нөхцөл байдалд гол анхаарлаа хандуулж морин хуур хөгжимд суралцагчдын хандлагыг үнэлэх хэмжүүр боловсруулж баталгаажуулах зорилготой.

МУБИС, Багшийн сургуулийн бага ангийн болон хөгжмийн багш мэргэжлээр суралцаж буй (1-4)-р курсийн 388 оюутны дунд уг судалгааг явууллаа. Судалгааны үр дүнгээс үзэхэд боловсруулсан хэмжүүрийн хүчинтэй байдал (validity) фактор шинжилгээний үр дүн хуримтлагдсан тархалтын нийлбэр нь 62.471, КМО (түүврийн нийцтэй байдал) 0.908, $p=0.00 < 0.05$, найдвартай байдлыг (reliability) тодорхойлох Коронбахын альфа коэффициент 0.903 байгаа нь уг хэмжүүр нь оновчтой болсон төдийгүй гарсан үр дүн нь эх олонлогтоо хүчинтэй байгааг харуулсан. Морин хуурт хандах хандлага тодорхойлох уг хэмжүүр дөрвөн фактор илэрсэн. Үүнд фактор 1 - зан үйлд хандах, фактор 2 -т соёлын биет бус өвийг хайрлан хамгаалахтай холбоотой хандлагыг илэрхийлэх, фактор 3-д суралцах зан үйлийн хандлагыг илэрхийлэх, фактор 4 -д танин мэдэхүйн хандлагыг илэрхийлэх үзүүлэлтүүд тус факторлагдсан байна.

Монголын соёлын өвийг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, хөгжмийн боловсролыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.

Түлхүүр үг

Морин хуур, хандлагын хэмжүүр, монгол өв соёл, хөгжмийн боловсрол, статистик шинжилгээ

Удиртгал

Морин хуур нь Монголын соёлын өвийн нэг юм. Хүзүүндээ морины толгойн өвөрмөц сийлбэрээрээ онцлогтой энэхүү уламжлалт нуман чавхдаст хөгжим

нь Монгол үндэстний бэлгэдэл төдийгүй нүүдэлчин ахуй соёлын арвин баялаг түүхийг хойч үедээ өвлүүлэн үлдээж байгаа гол зэмсэг юм. Морин хуурын өвөрмөц аялгуу нь сэтгэл хөдлөл, түүхийг дамжуулах чадвартай бөгөөд монголчуудын баяр ёслол, зан үйл, өдөр тутмын амьдралд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ингэснээр ард түмнийхээ зүрх сэтгэл, оюун санаанд гүн гүнзгий нөлөөлдөг.

Морин хуурын талаар эрдэмтэн судлаачид олон арван бүтээлүүд туурвисан байна. Морин хуурын домог зан үйлийн талаар судлаач С. Дулам, Юань үеийн ба XI зууны зэмсэгт хөгжмийн талаар судлаач Г.Бадрах, монголчуудын язгуур хөгжмийн зэмсэг чиглэлээр Ж.Бадраа, морин хуурын дуурьсах авианы өвөрмөц онцлогийг орчин үеийн ба эртний дорно дахины хөгжмийн онол арга зүйн талаас нь Л.Эрдэнэчимэг, монгол ахуй, аж төрөх ёс, монгол хөгжмийн сэтгэлгээнд холбогдох чиглэлээр Ж.Энэбиш, Н.Жанцанноров нарын эрдэмтэн судлаачид судалжээ. Мөн морин хуурын домог, үг зүйн утга, уртын дууны харилцаа хамаарал, түүхэн эх сурвалж талаар, бэлгэдэл зан үйл, уламжлалт байдлын онцлог, хийц төрөл зүйл, уламжлал зэргийг дараах эрдэмтэд судалжээ. Үүнд: Д.Ханджав, Д.Оюунцэцэг, С.Бадрал, С.Соронзонболд, Д.Энхцэцэг, П.Байгальжав, Д.Уламбаяр, Г.Мэнд-Ооёо, Б.Смирнов зэрэг эрдэмтэн судлаачдыг дурдаж болно. Мөн морин хуур хөгжмийн орчин цагийн хөгжлийн талаар Америкийн судлаач Петр Марш, морин хуур чуулгын хуурчдын хуурдах ур чадварын талаар С.Батчулуун нар судалсан байна. Морин хуурын сургалт, арга зүйн талаар С.Мягмаржав, Д. Пүрэвдорж, Г.Жамьян, Ё. Батбаяр Английн хөгжим судлаач Легий нар судалсан байна. Үүний дотор Г.Жамьян (1978) “Морин хуур сурах гарын авлага” номдоо морин хуур хөгжим хэрхэн тоглож сурах, түүнийг сурагчдад хэрхэн заан сургах талаар өгүүлсэн. Энэ нь салбарын эрдэмтэн, судлаачдын дунд үнэ цэнтэй бүтээл болдог.

Морин хуурын талаар сүүлийн жилүүдэд судлаачид ихээхэн сонирхон судалж эрдэм шинжилгээний өгүүлэл, магистрын болон докторын судалгааны ажил хийгдэж байна.

Эрдэмтэн судлаач Л.Эрдэнэчимэг “Морин хуурын арга билгийн арван хоёр эгшиглэн (2019, хуудсд. 6-7)” бүтээлдээ морин хуурын үүсэл хөгжлийн талаар түүхэн талаас нь судалсан эрдэмтдийн бүтээлүүдээс сонирхолтой дүгнэлтүүд гаргасан байдаг. Тухайлбал Г.Бадрах Монгол хөгжмийн түүх (1960, хууд. 105) бүтээлдээ дүнху нарт хуур байсан болохоор “Хүннү нарт хуур байх үндэстэй, нангиад сурвалжийн мэдээгээр хүннү нарт байсан хуурын төрлийн хөгжмийн зэмсэг ху күн ху нь нумт чавхдаст хөгжим юм” гэдэг талаар эрдэмтэн доктор Г. Сүхбаатар (Монгол нирун улс (330-555), 1992, хууд. 226) тэмдэглэсэн байна. Судлаач Чи.Булаг (1990, хууд. 23) Умард Сүн улсын зохиолч Вү Ян шүү - ийн тэмдэглэсэн “Сэн Янгийн хөгжмийн бичиг” (1010 он) 128 дугаар эвхмэлээс ишлэн: “ший чин хуурыг хүн үүсгэсэн болохоор ший хүн сонсоод нулимс унагана “Кү му ший нь эртний дунгу нартай удам нэгтэй хөгжиж ирсэн аймаг” гэжээ. Монгол тулгуур төрийн үед (12-13 зуунд) монгол нутагт хуур хөгжим байсан түүнийг үзсэн харсан тухайгаа харийн орны жуулчид бичиж үлдээсэн зүйл арвин. Г.Рубрук аян замын тэмдэглэлдээ: “Монгол зон бол айраг исгэж үүдэн хавьд тавина, дэргэд нь ямагт хуур барьсан хүн суулгана, европт үзэгдээгүй хөгжим энд маш олноор үзэгдэнэ” хэмээжээ. “Марко Пологийн Жуулчлалын тэмдэглэл” - д тэмдэглэснээр, XII зууны манлай татаар хүмүүст

нэгэн зүйлийн хоёрдугаар чавхдаст хөгжим дэлгэрсэн.. Мин, Чин Улсын үед ордны хамтлагт хэрэглэж байжээ. Уламжлагдсан газар нутгийн адилгүйн улмаас түүний нэр, хэлбэр, дуу, тоглох арга нь ч өөр өөр байдаг. Өвөр монголын баруун бүс нутагт “Мээриний Хүрэн буйр, Жирэмийн аймаг, Зуу - удын чуулганд “ Чур ” гэдэг, бас “өхэр”, “ хуур ”, “ морин хуур ”, “ нумын хуур ” зэрэг нэртэй. Багийн Өвөр монголоос гадна Ляонин, Гирин, Хармөрөн, Ганьсү, Шиньжян зэрэг газрын монголчуудад өргөн дэлгэрчээ (Cui Rong, 2007).

Хөгжим судлаач N.Grove (Grove, 1888, p. 37), R,Hamayan (1980) G,Gemeling (Goswamy, 1957.p.86) нар хөгжмийн толь бичигт “ Чингис хаан өөрийнхөө улс төрийн гэргийг хамаг хайртай хуурч Аргасун гүйцэтгүүлж байв. Тэд францийн дөрөв дүгээр Филиппийн хооронд хуурч, дууч хүмүүнийг илгээдэг байв” гэж бичсэн байдаг. Судлаач бүрэн морин хуурын үүсэл хөгжлийн талаар Юань улсын төрт ёсны хөтөлбөр “арван буянт номын цагаан түүх”-ээс сурвалжлан “хааны ордонд хуурч, цуурч, дууч нар байв” гэж тэмдэглэсэн байдгийг эш татан тайлбарлажээ. Монголчууд хуурыг янз бүрээр урлаж зарим нутагт цоор хуур хэмээн толгойг нь дүрсгүйгээр урлаж байсан бол зарим нутагт хохимой толгой, үхэр, матар, луу, морины толгойг янз янзаар сийлбэрлэн дүрсэлж байжээ. Түүхэн сурвалжид тэмдэглэсэнээр “модоор зүүн баруун чиг зохион ширхгийн морины хялгасыг уяна” гэснээс үзэхэд чавхдасны тоо ширхгийг анхааран тооцдог байсан нь илэрхий байна (Чи.Булаг, Морин хуурын мэргэжил, 1981, хууд. 125). Мөн Шведийн жуулчин К.Хаслунд 1943 оны үед хорчин монголчуудыг сурвалжлан хуурын гэрэл зургуудыг авснаа Стоккульмд хэвлүүлжээ (Eckardt, 1930,p.29-32). Морин хуурыг биетээр нь дэлхийн олон орны музейн үзмэрт тавьсан, дуурслыг нь соронзон бичлэгээр хэвлэж гаргасан зүйл олон.

Судлаач доктор Г.Заяабат (2024, хуудсд. 13-14) “Ардын хөгжмийн зэмсэг судлал” бүтээлдээ Морин хуур хөгжмийн үүслийг судлаачид хоёр ангилж үздэг. 1. Монголын ард түмэн морин хуурын үүслийн талаар “Хөхөө Намжилын домог”, “Аргусан хуурчийн домог”, “Жонон харын домог” г.м үлгэр домог ам дамжин хэлэлцсээр ирсэн.

Морин хуур нь Монгол үндэстний соёлын үнэт зүйлийн нэг бөгөөд төрийн ёслолоос эхлэн ард түмний дунд, айл гэрийн хоймор залагдан ирсэн билээ. Иймд даяаршил, шинэчлэл нь шинэ хөгжмийн төрөл, нөлөөллийг бий болгож, Монголын залуучуудын уламжлалт соёл, урлаг хүлээн авах хандлагад нөлөөлж болзошгүй юм. Сүүлийн жилүүдэд дэлхийн хэмжээнд уламжлалт хөгжмийн төрлүүдийн талаарх эрдэм шинжилгээ, судалгааны ажлууд ихээхэн нэмэгдэж, сонирхон судалж, залуу үеийнхэн хэрхэн хүлээж авч байгаа талаар хэлэлцүүлэг өрнүүлж байна. Энэхүү судалгааны ажил нь соёлын залгамж чанарын эгзэгтэй хэр нь дутуу судлагдаагүй тал буюу оюутнууд морин хуур хөгжимд хандах хандлагыг судалсан болно.

Судалгааны арга зүй

Морин хуурд хандах хандлага тодорхойлох хэмжүүрийн нэгэн хувилбар боловсруулахдаа биет бус соёлын өвийн хамгаалах бодлого (ЮНЕСКО, 2003), төлөвлөсөн зан үйлийн онол (Theory of Planned Behavior) хамаардаг (Ajzen, I., 1985; 1991), нийгмийн өвөрмөц байдлын онолд (Social Identity Theory) (Tajfel, H.,

& Turner, J. C. , 1979) үндэслэн боловсруулсан. Уг хэмжүүр нь 18 асуултаас бүрдэх ба лайкертийн 1-огт санал нийлэхгүй байна, 2-ерөнхийдөө санал нийлэхгүй, 3-дунд зэрэг, 4-ерөнхийдөө санал нийлж байна, 5 - бүрэн санал нийлж байна гэсэн таван шатлалаар хэмжээслүүлсэн.

Хэмжүүрийн уг хувилбараар МУБИС -ийн Багшийн сургуулийн бага ангийн багш болон дуу, хөгжийн I-IV курсийн нийт 388 оюутнуудаас судалгаагаа авсан.

Судалгааны хэмжүүрийн найдвартай байдал (Кронбах-Альфа), Хуваарийн бүтцийн хүчинтэй байдлыг хайгуулын хүчин зүйлийн шинжилгээ, баталгаажуулах хүчин зүйлийн шинжилгээгээр шалгасан. Морин хуурт хандах хандлагыг оюутнуудын хүйс, нас, мэргэжил зэргээс хамаарч буй эсэхийг шинжлэн судалсан.

Судалгааны үр дүн

Судалгаанд 18-24 насны 388 оюутны дунд судалгаа явуулсан. Түүнээс 18 нас - 8.2%, 19 нас - 15.5 %, 20 нас- 26.3%, 21 нас – 22.9%, 22 нас- 23.2%, 23 нас -3.1, 24 настай нь -8% эзэлж байна. Судалгаанд хамрагдсан 388 оюутны 9 % нь эрэгтэй, 91 % нь эмэгтэй байв. Судалгаанд нийт хамрагдсан оюутны 46 буюу 12 % нь морин хуур тоглож чадна, 342 буюу 88% чадахгүй гэж хариулсан байна.

Дээрх зургаас үзэхэд морин хуур тоглож чаддаг гэж хариулсан 46 оюутны 20 нь бага ангийн багш, 26 нь дуу хөгжмийн багшийн ангийн оюутан байв. Энэ нь мэргэжлийн бус ангийн оюутнууд ч морин хуурыг сонирхдог болох нь харагдаж байна.

МУБИС -ийн Багшийн сургуульд 1400 гаруй оюутан суралцаж байна. Үүнийг төлөөлж чадах түүврийн хэмжээг www.calculator.net ашиглан 95 хувийн итгэлтэй байх завсарт тооцоолж үзэхэд 306 гарсан нь 388 оюутан хамрагдсан нь хангалттай болохыг илтгэж байна. Бидний боловсруулсан оюутнуудын морин хуурт хандах хандлагыг хэмжих хэмжүүрийн нэгэн хувилбарыг 18 асуултын найдвартай байдал

Хүснэгт 1 Судалгааны асуулгын найдвартай байдал

Кронбахын Альфа коэффициент	Тоо
.903	18


Кронбахын Альфа коэффициент нь 0.70 - аас их байвал хангалттай гэж үздэг (Hair et all, 2016, Лувсандорж.Ц 2021). Бидний боловсруулсан хэмжүүрийн Кронбахын Альфа нь 0.903 гарсан нь хувьсагчид болох асуултуудын дотоод нийцэл нь маш сайн байгааг илтгэж байна.

Хүснэгт 2 Хэмжүүрийн асуулт бүрийн Кронбахын альфа утга

	Scale Mean if Item Deleted	Scale Variance if Item Deleted	Corrected Item-Нийлбэр Correlation	Squared Multiple Correlation	Cronbach's Alpha if Item Deleted
Би морин хуурын аялгуу сонсох дуртай.	64.92	133.550	.603	.550	.896
Морин хуурыг өвлүүлэн уламжлуулах нь чухал гэдэгт би итгэдэг.	64.69	136.426	.614	.647	.896
Нийтийн хөгжмийн боловсролд морин хуурын ач холбогдлыг би өндөр үнэлдэг.	64.92	136.345	.617	.583	.896
Манай гэр бүлийнхэн морин хуураар дамжуулан өв соёлоо танин мэдэхэд чухал гэж үздэг.	65.41	135.861	.511	.395	.899
Манай үеийнхэн морин хуур хөгжим төдийлөн сонирхдоггүй.	65.91	143.351	.203	.169	.908
Манай нутагт морин хуурчийг хүндэлдэг.	65.24	136.683	.507	.378	.899
Би алдартай морин хуурчид, хамтлагийг мэднэ.	65.75	135.516	.454	.375	.901
Надад морин хуур тоглож сурах хангалттай боломж байгаа гэж бодож байна.	65.27	132.452	.644	.566	.895
Би морин хуур тоглож сурах сонирхолтой.	65.14	133.142	.638	.605	.895
Би морин хуурын тоглолтыг сонсох эсвэл үзэх боломжийг эрэлхийлдэг.	65.39	132.265	.685	.615	.894
Би морин хуурын талаар илүү ихийг мэдэх сонирхолтой.	65.35	131.814	.658	.583	.894
Би морин хуур үүссэн домгийг мэддэг.	65.71	135.149	.461	.296	.901
Би морин хуурын төрөл зүйлийн талаар сайн мэддэггүй.	65.80	138.371	.357	.195	.904
Би морин хуур хөгжмийн бүтцийг мэднэ.	65.73	133.319	.515	.404	.899
Морин хуур хөгжим нь Монголын өв соёлтой харилцах харилцааг дөхөм болгодог.	65.25	133.432	.657	.550	.895
Би морин хуур хөгжмийг монголын соёлын өвийн хосгүй хэсэг хэмээн бахархдаг.	64.92	134.911	.631	.644	.895
Би морин хуурыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг дэмждэг.	65.10	132.644	.712	.631	.893
Дэлхийн хөгжмийн ертөнц, соёлын олон талт байдалд морин хуур нь чухал байр эзэлдэг.	64.90	134.540	.703	.668	.894

Хэмжүүрийн асуулт бүрийн Кронбахын Альфа нь 0.889 – 0.908 байгаа нь асуултууд найдвартай хангалттай байгааг илтгэж байгаа бөгөөд дотоод нийцэл өндөр байгааг харуулж байна.

“Манай үеийнхэн морин хуур хөгжим төдийлөн сонирхдоггүй” гэсэн асуултад хариулсан байдал.



Дээрх графикаас үзэхэд нийт судалгаанд хамрагдсан оюутнуудын 38 хувь нь манай үеийнхэн морин хуур сонирхдоггүй, 36 хувь зарим талаар санал нийлсэн, харин 23 хувь нь сонирхдог болох нь харагдаж байна. Энэ үр дүнгээс үзэхэд морин хуур хөгжмийг оюутан залуусын дунд сонирхлыг нь нэмэгдүүлэх ажлууд хийгдэх шаардлагатай нь харагдаж байна.

Бид оюутнуудын морин хуурт хандах хандлага хэмжих аргачлалын нэгэн хувилбарын хүчинтэй байдлыг үнэлж үзэх, цаашид хөгжүүлэх үүднээс фактор шинжилгээ хийлээ.

Хүснэгт 3 Морин хуур хөгжимд хандах хандлагын факторын варимакс

Асуултууд	Фа1	Фа2	Фа3	Фа4
Хувийн утга	3.123	3.076	3.062	1.985
Варианс /Variance/ (%)	17.348	17.087	17.01	11.026
Хуримтлагдсан тархалт %	17.348	34.434	51.445	62.471

Факторын шинжилгээ хийж үзэхэд бидний 18 асуулт нь хувийн утга нь 1 -ээс дээш дөрвөн хүчин зүйлд хуваагдсан. Факторын ачаалал нь 0.4 дээш бол ач холбогдолтой, 0.5 аас дээш бол маш их ач холбогдолтой хувьсагч юм. Хуримтлагдсан тархалтын нийлбэр нь 63.689 гарсан ба нийгэм, хүмүүнлэгийн ухаанд 60 хувиас дээш бол ач холбогдолтой гэж үздэг (Hair, J., Black, W., Babin, B., & Anderson, R., 2019). КМО - түүврийн нийцтэй байдал 0.948, $p=0.00$ нь 0.05 бага байгаа учир фактор шинжилгээ ач холбогдолтой байгааг илтгэж байна.

Фактор -1 (Ф1) -д “Морин хуурыг өвлүүлэн уламжлуулах нь чухал гэдэгт би итгэдэг”, “Нийтийн хөгжмийн боловсролд морин хуурын ач холбогдлыг би өндөр үнэлдэг”, “Манай нутагт морин хуурчийг хүндэлдэг”, “Манай гэр бүлийнхэн морин

хуураар дамжуулан өв соёлоо танин мэдэхэд чухал гэж үздэг”, “Би морин хуурын аялгуу сонсох дуртай” гэсэн асуултууд нь зан үйлд хандах хандлагыг илэрхийлэх хувьсагчууд факторлогдсон байна.

Фактор -2 (Ф2) -д “Би морин хуур хөгжмийг монголын соёлын өвийн хосгүй хэсэг хэмээн бахархдаг”, “Дэлхийн хөгжмийн ертөнц, соёлын олон талт байдалд морин хуур нь чухал байр эзэлдэг”, “Би морин хуурыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг дэмждэг”, “Морин хуур хөгжим нь Монголын өв соёлтой харилцах харилцааг дөхөм болгодог” гэсэн морин хуур хөгжим соёлын биет бус өвийг хайрлан хамгаалахтай холбоотой хандлагыг илэрхийлэх хувьсагчууд факторлогдсон байна.

Фактор -3 (Ф3) -д “Би морин хуур тоглож сурах сонирхолтой”, “Надад морин хуур тоглож сурах хангалттай боломж байгаа гэж бодож байна”, “Би морин хуурын тоглолтыг сонсох эсвэл үзэх боломжийг эрэлхийлдэг”, “Би морин хуурын талаар илүү ихийг мэдэх сонирхолтой”, “Би алдартай морин хуурчид, хамтлагийг мэднэ” гэсэн суралцах зан үйлийн хандлагыг илэрхийлэх үзүүлэлтүүд факторлагдсан байна.

Фактор -4 (Ф4) -д “Манай үеийнхэн морин хуур хөгжим төдийлөн сонирхдоггүй”, “Би морин хуур хөгжмийн бүтцийг мэднэ”, “Би морин хуур үүссэн домгийг мэддэг”, “Би морин хуурын төрөл зүйлийн талаар сайн мэддэггүй” гэсэн танин мэдэхүйн хандлагыг илэрхийлсэн үзүүлэлтүүд тус факторлагдсан байна.

Дүгнэлт

Морин хуур хөгжимд хандах хандлагын хэмжүүрийн нэгэн хувилбарын онол арга зүйн хүрээнд ном зүйн талаарх тойм судалгааны үр дүн, соёлын биет бус өв, төлөвлөсөн зан үйлийн онол, нийгмийн өвөрмөц байдлын онол дээр үндэслэн хэмжүүр боловсруулж МУБИС -ийн Багшийн сургуулийн бага ангийн багш болон дуу, хөгжмийн багш мэргэжлээр суралцаж буй I-IV курсийн оюутнуудаас судалгаа авч дараах дүгнэлтийг хийж байна.

- Оюутнуудын морин хуурт хандах хандлага тодорхойлох хэмжүүрийн хүчинтэй байдал (validity) фактор шинжилгээний үр дүн хуримтлагдсан тархалтын нийлбэр нь 62.471, КМО (түүврийн нийцтэй байдал) 0.908, $p=0.00 < 0.05$, найдвартай байдлыг (reliability) тодорхойлох Коронбахын альфа коэффициент 0.903 байгаа нь уг хэмжүүр нь оновчтой болсон төдийгүй гарсан үр дүн нь эх олонлогтоо хүчинтэй байгааг нотлон харуулж, судалгааны ажлын таамаглал батлагдаж байна.
- Асуулт бүрийн Кронбахын Альфа нь 0.889 – 0.908 байна. Энэ нь асуултуудын дотоод нийцэл өндөр байгааг харуулж байна.
- Морин хуурт хандах хандлага тодорхойлох нь хэмжүүр нь шинээр боловсруулсан учир фактор хайх шинжилгээ хийж үзэхэд дөрвөн фактор илэрсэн. Фактор 1 - зан үйлд хандах, фактор 2 -т соёлын биет бус өвийг хайрлан хамгаалахтай холбоотой хандлагыг илэрхийлэх, фактор 3-д суралцах зан үйлийн хандлагыг илэрхийлэх, фактор 4 -д танин мэдэхүйн хандлагыг илэрхийлэх үзүүлэлтүүд тус факторлагдсан байна.
- Хэмжүүрийн асуулт бүрийн дундаж үзүүлэлт нь хөгжмийн багшаар бэлтгэгдэж буй оюутнуудын дундаж үр дүн нь бага ангийн багш мэргэжлээр суралцаж буй

оюутнуудаас илүү өндөр байна. Энэ нь эзэмшиж буй мэргэжилтэй нь холбоотой болох нь харагдаж байна. Судалгаанд хамрагдсан мэргэжлийн ангийн 107 оюутны морин хуур хөгжимд хандах хандлага өндөр буй байгаа хэдий ч 26 нь морин хуур тоглож чадна гэж хариулсан байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд дуу хөгжмийн багшийн ангийн оюутнууд төдийгүй бага ангийн багшаар суралцаж буй оюутнууд морин хуур тоглож сурах хүсэлтэй оюутнууд их байна. Иймээс хөгжмийн мэргэжлийн багш ба бусад чиглэлийн багш мэргэжлээр суралцаж буй морин хуур хөгжим сурах сонирхолтой оюутнуудад зориулсан “Морин хуур” нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх. Энэ нь морин хуур соёлын өвийг түгээн дэлгэрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

“Манай үеийнхэн морин хуур хөгжим төдийлөн сонирхдоггүй” гэсэн урвуу асуултад судалгаанд хамрагдсан оюутнуудын 38 хувь нь санал нийлж байгаа нь монгол түмний бахархал, соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх, энэ чиглэлийн судалгааны ажлыг өргөн хүрээнд хийх шаардлагатай болох нь харагдаж байна.

Ном зүй

(2004, 9 1). Retrieved from legalinfo.mn: <https://legalinfo.mn/mn/detail/787>

(2008). Retrieved from unesco.org: <https://ich.unesco.org/en/RL/urtiin-duu-traditional-folk-long-song-00115#>

Ajzen, I. (1985). From intentions to actions: A theory of planned behavior. Springer-Verlag.

Ajzen, I. (1991). The theory of planned behavior. Organizational Behavior and Human Decision Processes.

Cui Rong, B. (2007). Үүрдийн морин хуур. Морин хуурын урлагийн боловсролын тэмдэглэл.

Eckardt. (1930,p.29-32). Koranische music . Tokyo .

Goswamy, O. (1957.p.86). The story of indian music its growth and synthesis. Bombay.

Grove, N. (1888). Contribution a l'etude de la musique hindoue.

Hair, J., Black, W., Babin, B., & Anderson, R. (2019). Multivariate Data Analysis. Cengage Learning.

Hayashi. (1980). Toyo ongaku kenkyu (oriental music research). Tokyo.

Tajfel, H., & Turner, J. C. . (1979). An integrative theory of intergroup conflict. In W. G. Austin & S. Worchel (Eds.), The social psychology of intergroup relations. Monterey: CA: Brooks/Cole.

Алимаа, А. (2013). Монгол уртын дууны төрөл зүйл, тархалт, хувилбарын онцлог. Улаанбаатар: УБ Экспресс.

Бадрах, Г. (1960). Монгол хөгжмийн түүх. Улаанбаатар.

Жамьян, Г. (1978). Морин хуур сурах гарын авлага. Улаанбаатар.

Жанцанноров.Н. (2006). Уртын дууны нэр томъёоны гаргалгаа. Улаанбаатар.

Заяабат, Г. (2024). Ардын хөгжмийн зэмсэг судлал. Улаанбаатар хот.

Сүхбаатар, Г. (1992). Монгол нирун улс (330-555). Улаанбаатар.

Чи.Булаг. (1981). Морин хуурын мэргэжил. Хөх хот.

Чи.Булаг. (1990). Чингисийн эр хоёр загалын тууж оршивой. Улаанбаатар.

Эрдэнэчимэг, Л. (2019). Морин хуурын арга билгийн арван хоёр эгшиглэн. Улаанбаатар: ”Удам соёл” ХХК.

RESULTS OF DEVELOPING AND TESTING A VERSION OF AN ATTITUDE MEASUREMENT TOOL FOR THE HORSE-HEAD FIDDLE (MORIN KHUUR) INSTRUMENT

^aBatkhuuyag S., ^bUsukhbayar B., ^cSARENCHAOGETU

^aPh.D., Lecturer, Teachers School, MNUE;

^bTeachers School, MNUE;

^cNational University, China, Inner Mongolia, Tongliao

Corresponding author: batkhuyag@msue.edu.mn 

Abstract

This study developed and tested a measurement tool to determine how students perceive the horse-head fiddle (morin khuur) instrument. The results were analyzed and examined. Using this measurement, a survey was conducted with 388 students from years 1-4 in the primary education and music education departments at the Mongolian State University of Education.

The results of the study show that the validity of the developed measurement tool is effective, with the cumulative distribution sum from factor analysis at 62.471, KMO (sample compatibility) at 0.908, $p=0.00 < 0.05$, and Cronbach's alpha coefficient determining reliability at 0.903. This indicates that the measurement tool is appropriate and the results are valid for the population.

As the measurement tool for determining attitudes towards the horse-head fiddle was newly developed, an exploratory factor analysis was conducted, revealing four factors. Factor 1 relates to behavioral attitudes, factor 2 expresses attitudes related to preserving intangible cultural heritage, factor 3 expresses learning behavior attitudes, and factor 4 expresses cognitive attitudes.

This research has significant importance in a wide range of areas, including the protection and promotion of Mongolian cultural heritage and the development of music education.

Keywords

Horse-head fiddle (morin khuur), attitude measurement tool, reliability and validity